ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 30 ДУГААР ЗҮЙЛ (ЭРХ ЗАЛГАМЖЛАЛ)-Д ХОЛБОГДОХ СУДАЛГАА

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2023/02/09

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2023.02.15

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 2
УДИРТГАЛ 3
НЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 4
1. АНУ 4
2. ИБУИНХУ 7
3. Япон Улс 7
4. БНСУ 10
5. БНХАУ 12
6. ОХУ 15
ХОЁР. ДҮГНЭЛТ 18
ЭХ СУРВАЛЖ 21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХХШтХ	Арбитрын Хэрэг Хянан Шийдвэрлэх тухай Хууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хант Улс
ИПХ	Иргэний Процессын Хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ХХШ	Хэрэг хянан шийдвэрлэх
ШССМХ	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

УДИРТГАЛ

Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын ИХШХШтХ-ийн 30 дугаар зүйл буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авахтай холбоотой зохицуулалтын харьцуулсан судалгааг хийсэн болно.

Судалгааны хамрах хүрээ

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах нөхцөл байдал үүссэн (зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан) тохиолдолд эрх залгамжлах ажиллагааг хэрхэн шийдвэрлэдэг талаар гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан эрх зүйн хүрээнд судлахаар АНУ, Япон Улс, БНХАУ, ОХУ болон БНСУ-ыг сонгон авлаа.

Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ түүхчлэн судлах, харьцуулсан судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

Судалгааны бүтэц

Судалгааны ажлын Нэгдүгээр бүлэгт, Харьцуулсан судалгаа, Хоёрдугаар бүлэгт дүгнэлт байгаа болно.

НЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. АНУ

АНУ нь Холбооны улс тул муж улс бүр өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон хууль тогтоомжийг батлах эрхтэй байдаг. Гэсэн хэдий ч, хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, ард иргэдэд ойлгомжтой болгох үүднээс муж улс болгонд үйлчлэх хууль тогтоомжийг батлан мөрдүүлэх, муж улсууд дотоодын хууль тогтоомжоо батлахдаа загвар болгон ашиглах Холбооны хуулийг батлах боломжтой. Энэ утгаараа Иргэний Процессын тухай Холбооны хууль (Federal Rules of Civil Procedure) нь АНУ-ын бүхий л муж улсад хүчин төгөлдөр үйлчлэх иргэний хэрэг маргааныг зохицуулах гол эх сурвалж болдог.

Тус хуулийн 25 дугаар зүйлд “Зохигчийг солих” (Subsitution of parties) үндэслэл болон журмын талаар зохицуулсан байна.

> ***25 дугаар зүйл. Зохигчийг солих***
>
> ***а) Нас барах***
> *1) Хэрэв зохигч нас барсан бөгөөд маргааны шаардлага үүгүй болоогүй бол, **шүүх нас барсан зохигчийг зохих этгээдээр солих захирамжийг гаргаж болно.** Зохигчийг солих хүсэлтийг нас барсан зохигчийн эрх залгамжлагч, төлөөлөгч болон **хэргийн аль ч тал шүүхэд гаргах боломжтой.** Хэрэв нас барсан тухай мэдэгдсэнээс хойш **90 хоногийн дотор** зохигчийг солих хүсэлтийг гаргаагүй бол, нас барсан этгээдийн шаардлага эсхүл түүний эсрэг гаргасан шаардлагыг **хэрэгсэхгүй болгоно.***

Түүнчлэн Давж заалдах журмын тухай Холбооны хууль (Federal rules of Appellate Procedure)-д давж заалдах шатанд зохигчийг солих асуудлыг дэлгэрэнгүй байдлаар зохицуулжээ.

> ***43 дугаар зүйл. Зохигчийг солих***
>
> ***а) Зохигч нас барах***
> ***1) Давж заалдах гомдол гаргасны дараа.** Хэрэв давж заалдах гомдол гаргасны **дараа** эсхүл давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа **үргэлжилж байх үед** зохигч нас барсан бол, аль ч зохигч болон зохигчийн төлөөлөгч тухайн зохигчийн төлөөлөгчөөр зохигчийг солих хүсэлтийг шүүхийн нарийн бичгийн даргад гаргаж болно. Хэрэв нас барсан зохигчид төлөөлөгч байхгүй тохиолдолд, **давж заалдах шатны шүүх тохиромжтой арга хэмжээг авна.***

Дээрх холбооны хууль тогтоомжоос гадна АНУ-ын муж улсууд эрх залгамжлалтай холбоотой дэлгэрэнгүй зохицуулалтуудыг өөрсдийн мужийн хуульдаа тусгаж өгсөн байдаг.

АНУ-ын Флорида муж[1]:

АНУ-ын Флорида мужид хэргийн оролцогч буюу зохигчийн хэн нэг нь нас барсан бол хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбоотой харилцааг тухайн мужийн дотоодын ИПХ-аар зохицуулдаг.

Энэ тохиолдолд нас барсан этгээдийн төлөөний эрх залгамжлан авах хүсэлтэй этгээд шүүхэд хүсэлт гаргах үүрэгтэй ба энэ баримт бичгийн зорилго нь нас барсан этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хөрөнгийн эзэн, маргааны зүйлийн өмчлөгч байсан, энэ эрхээ түүнийг төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх олж авч байгаа этгээдэд шилжүүлсэн гэж эрх залгамжлагчийн зүгээс нотлох баримт болох юм.

[1] https://jflawfirm.com/what-happens-if-someone-dies-before-settlement-in-a-civil-lawsuit/ (Сүүлд үзсэн: 2022.11.03).

Хамгийн анхаарууштай нь **иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч тал нас барсан тухай мэдсэнээс хойш 90 хоногийн дотор эрх залгамжлах тухай хүсэлтийг шүүхэд гаргах ёстой** байдаг.

Хуульд зааснаар, иргэний хэргийг хянан шийдвэрлэж **шүүхээс шийдвэр гарахаас өмнө нэхэмжлэгч нас барсан тохиолдолд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгохгүй, харин түр түдгэлзүүлдэг байна.** Үүний дараагаар эрх залгамжлагчийг тогтоох хугацааг шүүхээс зааж өгөх ба энэ тохиолдолд нас барсан этгээдийн төлөөлөгч буюу эрх залгамжлагч нь нас барсан этгээдийн эд хөрөнгө ба түүний гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хэсгийг төлөөлж шүүхийн процесс ажиллагаанд үргэлжлүүлэн оролцоно.

Эрх залгамжлагчаар нас барсан этгээдийн өв залгамжлагч нарыг тогтоож болох ба нас барсан этгээдийн хөрөнгийн эсрэг гаргасан нэхэмжлэлийн хувьд түүний өв залгамжлагч нь өвлөх эрхтэй этгээд болох тул түүнийг төлөөлөх боломж бий. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ зохицуулалт нь эрүүгийн эрх зүйгээс иргэний эрх зүйг ялгах гол түлхүүр болдог. Учир нь эрүүгийн эрх зүйд шүүгдэгч нас барсан тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгодог.

Дээр дурдсан эрх залгамжлагчийг тогтоох хүртэл процесс ажиллагаа буюу иргэний хэрэг хянан шийдвэрлэх **ажиллагааг түдгэлзүүлэх нөхцөл нь хариуцагч нас барсан тохиолдолд ч хэрэгжинэ.**

Иймд **хариуцагч хэдийгээр нас барсан ч түүний эд хөрөнгийн эсрэг нэхэмжлэгч талаас нэхэмжлэл гаргах эрхтэй.** Нэхэмжлэгч нар нь хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй боловч /punitive damage/ буюу шийтгэлийн шинжтэй нэмэлт нөхөн төлбөр төлүүлэх боломжгүй болдог байна.

АНУ-ын Жоржиа муж[2]:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад **хариуцагч нас барсан тохиолдолд** “punitive damage” буюу шийтгэлийн шинжтэй нэмэлт нөхөн төлбөрийг төлүүлэх боломж байдаггүй бөгөөд бусад нөхөн төлбөрийг гаргуулах тухай нэхэмжлэгч нар нь нэхэмжлэл гаргах эрхтэй, “хариуцагч нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн, түүнд хохирол учруулсан тул хариуцлага хүлээлгэх нь зүйтэй” боловч энэ нь хариуцагч нас барсны дараа нэлээд бэрхшээлтэй процесс болж хувирдаг байна. Энэ тохиолдолд **хариуцагчийн эсрэг бус хариуцагчийн хөрөнгийн эсрэг нэхэмжлэл гаргах нь зүйтэй.** Ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулах боломж бүрдэнэ.

Дараах тохиолдолд хариуцагч нас барсан хэдий ч нэхэмжлэлийн процесс хэвийн явагдах ба шаардлагатай тохиолдолд доор дурдсанаар хязгаарлагдахгүй:

a. Залилангийн гэмт хэрэг;
b. Хүчирхийлэлтэй холбоотой нэхэмжлэл;
c. Иргэний хэргийн зарим нэхэмжлэл;
d. Зээлдүүлэгчийн нэхэмжлэл;
e. Хүүхдийн амран тэтгэх, тэтгэмж гаргуулахтай холбоотой нэхэмжлэл.

Хариуцагч нас барсны дараагаар аль болох богино хугацаанд түүний эд хөрөнгийн эсрэг нэхэмжлэл гаргах /эсхүл нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх/ нь чухал. Эс бөгөөс нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргах эрхээ алдах сөрөг үр дагавартай. Ихэнх тохиолдолд дахин нэхэмжлэл гаргах энэхүү хугацаа нь **1 жил байна**.

[2] https://www.thejusticelawyer.com/blog/what-if-the-defendant-dies-in-litigation/ (Сүүлд үзсэн: 2022.11.04).

АНУ-ын Иллинойс муж[3]:

Нэхэмжлэл гаргахаас эхлээд хэрэг маргаан үүсгэж хянан шийдвэрлэх нь ихээхэн урт хугацааны үргэлжилсэн процесс ажиллагаа юм.

Энэхүү процесст **нэхэмжлэгч эсхүл хариуцагч нас барснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болохгүй. Шүүхээс нас барсан этгээдийн хувийн төлөөлөгч (итгэмжлэгдсэн төлөөлөгч), нас барсан этгээдийн хөрөнгийг удирдан зарцуулах гүйцэтгэгч гэх мэт этгээдүүдийг томилсноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн үргэлжилнэ.**

Тус муж нь The Survival Act гэх баримт бичгээр энэхүү харилцааг дэлгэрүүлэн зохицуулжээ. Энэхүү эрх зүйн эх сурвалжид дурдсанаар нэхэмжлэгчийг нас барахаас өмнө үүссэн болон үүсэх аливаа нэхэмжлэл гаргах шалтгаан болсон үйл явдлыг хэрэгсэхгүй болгохгүй байхад оршино. Энэхүү хуулийг батлагдахаас өмнө “нэхэмжлэгч нас барвал, нэхэмжлэл гаргах үндэслэл дуусгавар болно” гэж үздэг байжээ. ***The Survival Act-ын зорилго нь хэдийгээр нэхэмжлэгч нас барсан ч түүнд нөхөн төлөгдөх ёстой байсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлж нэхэмжлэлийг шийдвэрлэхэд оршино.***

Нэхэмжлэл гаргасны дараагаар нэхэмжлэгч нас барсан тохиолдолд түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч (хувийн төлөөлөгч) түүний өмнөөс нэхэмжлэлд оролцон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч нас барсан бол ихэнх тохиолдолд хариуцагчийн эд хөрөнгийн эсрэг нэхэмжлэлээ үргэлжлүүлэн гаргаж болдог.

АНУ-ын Индиана муж[4]:

Эрүүл мэндэд хохирол учруулсантай холбоотой нөхөн төлбөр гаргуулах тухай нэхэмжлэл эсхүл автомашины ослын даатгалын нөхөн төлбөртэй холбоотой нэхэмжлэлтэй маргаанд шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэхэмжлэгч нас барсан бол ихэнх тохиолдолд хөрөнгийг удирдаж буй этгээд /хөрөнгийн удирдлагын эрх олж авсан этгээд/ нас барсан этгээдийн өмнөөс шүүхэд хандан нэхэмжлэл гаргаж маргааныг хянан шийдвэрлүүлнэ.

Бусад тохиолдолд нас барсан этгээдийн өв залгамжлагч нь энэ эрхийг хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, **шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэхэмжлэгч нас барсан бол шүүхээс хэргийг “түр түдгэлзүүлэх тухай” шийдвэр гаргана. Түдгэлзүүлэхийг зорилго нь нас барсан нэхэмжлэгчийн эд хөрөнгөд хувийн төлөөлөгч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ томилоход шаардлагатай хугацааг шүүхээс олгох юм.** Хувийн төлөөлөгч томилогдсон даруйд төлөөлөгч нь нэхэмжлэгчийн эд хөрөнгийн нэрийн өмнөөс иргэний нэхэмжлэлийг үргэлжлүүлж болно.

Хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр гарахаас өмнө нас барсан бол хэргийг мөн түдгэлзүүлнэ. Иймхүү түдгэлзүүлэх хугацаанд нас барсан хариуцагчийн гэр бүлийн гишүүд шүүхээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгах ёстой. Хариуцагчийн эд хөрөнгийг захиран зарцуулах хувийн төлөөлөгч томилогдсоны дараа нэхэмжлэгч нь хариуцагчийн үл хөдлөх хөрөнгийн эсрэг нэхэмжлэл гаргаж болно.

[3] https://www.oflaherty-law.com/learn-about-law/is-a-lawsuit-in-illinois-terminated-if-one-of-the-parties-dies (Сүүлд үзсэн: 2022.11.04).
[4] https://www.truittlawoffices.com/blog/if-someone-dies-lawsuit-pending/ (Сүүлд үзсэн: 2022.11.07).

АНУ-ын хувьд нэхэмжлэгч эсхүл хариуцагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нас барсан тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгохгүй "түдгэлзүүлж" шийдвэрлэдэг. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд адил байдаг төдийгүй ийнхүү зохицуулахын зорилго нь "нэхэмжлэл гаргах болсон үндэслэл нэхэмжлэгчтэй хамт үхдэггүй" гэсэн зарчимд суурилах ба иргэний зөрчигдсөн эрхийг аль болох сэргээн эдлүүлэхэд (зарим тохиолдолд хариуцагч нас барсан бол түүнээс шийтгэлийн шинжтэй нөхөн төлбөр гаргуулах боломжгүй боловч бусад төрлийн нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй) дөхөм байхаар зохицуулсан онцлогтой байна.

2. ИБУИНХУ[5]

Маргааны аль нэг тал нас барахтай холбоотой ерөнхий зохицуулалт тус улсын ИПХ (CPR)-д доорх байдлаар тусгагджээ[6]:

> *ИПХ-ийн 19.8-д:*
> *(1) Нэхэмжилж буй асуудалд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд нас барсан ба тухайн этгээд итгэмжлэгдсэн төлөөлөгч (хувийн төлөөлөгч)-гүй тохиолдолд шүүхээс дараах эрхийг хэрэгжүүлж болно:*
> *a. Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхтэй этгээд байхгүй байсан ч нэхэмжлэлийн процессыг үргэлжлүүлэх,*
> *b. Нас барсан этгээдийн эрхийг залгамжлах этгээдийг томилох.*
> *(2) Хэрэв хариуцагч нас барсан тохиолдолд,*
> *a. Нас барсан зохигчийн эд хөрөнгийг захиран зарцуулах захирамж гарсан тохиолдолд, нас барсан зохигчийн хувийн төлөөлөгчийн эсрэг нэхэмжлэл гаргах шаардлагатай.*
> *b. Зохигчийн эд хөрөнгийг захиран зарцуулах захирамж гараагүй тохиолдолд,*
> *1. Нэхэмжлэлийг нас барсан зохигчийн эд хөрөнгийн эсрэг гаргана.*
> *2. Нэхэмжлэгч нас барсан зохигчийн эд хөрөнгийг хариуцах хариуцагчийг томилох хүсэлтийг шүүхэд гаргана.*
> *(5) Энэхүү зүйлд заасан аливаа захирамж, шүүхийн шийдвэр нас барсан зохигчийн эд хөрөнгөнд нэгэн адил хүчин чадалтай байна.*

ИБУИНХУ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч эсхүл хариуцагч нас барсан тохиолдолд хэргийг түдгэлзүүлж эрх залгамжлагчийг томилох, ийнхүү томилуулах хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүх эрх залгамжлагчийг томилох бүрэн эрхтэй байхаар зохицуулсан гэж үзэх боломжтой юм.

3. Япон Улс

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах тухай ерөнхий ойлголт

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлан авах (訴訟承継) гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх үед, нэхэмжлэлийн зүйлийн (訴訟物) талаарх нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн байр суурь гуравдагч этгээдэд шилжсэн тохиолдолд, тухайн зохигчийн байр суурь ч мөн гуравдагч этгээдэд шилжих явдал юм[7].

---

[5] https://www.hughjames.com/blog/what-happens-to-a-claim-when-a-person-dies (Сүүлд үзсэн: 2022.11.04).

[6] https://www.blcattorneys.co.za/2019/11/18/what-is-the-effect-of-death-of-the-plaintiff/ (Сүүлд үзсэн: 2022.11.04).

[7] 渡部美由紀他『民事訴訟法』238 頁（日本評論社　2016 年）。

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлан авах явдлыг ерөнхий байдлаар **Шууд залгамжлал (当然承継)** болон **Онцгой залгамжлал (参加承継、引受承継)** гэж 2 ангилдаг.

Шууд залгамжлал гэдэг нь зохигч болох хүн нас барах, хуулийн этгээд нэгдэн нийлэх зэрэг эрх залгамжлан авч буй этгээдийн хүсэл зоригоос хамааралгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагдах тохиолдол юм[8]. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг **түдгэлзүүлнэ.**

Онцгой залгамжлал гэдэг нь зохигч маргааны зүйлийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдол юм[9]. Энэ тохиолдолд, тодорхой процесс ажиллагааны үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагдах ёстой болдог.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах бүтэц

1. Шууд залгамжлал（当然承継）

Япон Улсын ИПХ-д Шууд залгамжлалын тухай зохицуулалт байхгүй боловч, Шууд залгамжлалын үр дагавар болох “хэргийг түр түдгэлзүүлэх зохицуулалт” (中断)-ын тусламжтайгаар шууд залгамжлалын үндэслэл болон үр дагаврыг тайлбарладаг.

ИПХ-ийн 124.1 дүгээр зүйлд дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түр түдгэлзүүлнэ гэж хуульчилсан:

- Зохигч нас барсан (ИПХ 124.1.1),
- Зохигч болох хуулийн этгээд өөр хуулийн этгээдтэй нэгдэн нийлсэн (ИПХ 124.1.2).

Түүнчлэн, ИПХ-аас гадна Дампуурлын тухай хуулийн 44.1 дүгээр зүйл болон 44.4 дүгээр зүйл дампуурлын хэрэг эхэлсэн эсхүл дуусгавар болсныг “хэргийг түр түдгэлзүүлэх тохиолдол” хэмээн хуульчилсан байдаг.

Дээр дурдсан эхний тохиолдол буюу ***зохигч нас барсан тохиолдолд*** хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжлан авах этгээд нь хууль ёсны өвлөгч эсхүл өвлөх эд хөрөнгийг зохицуулах эрх бүхий этгээд байна. Хоёр дахь тохиолдолд, хуулийн этгээд нэгдэн, нийлсний дараа шинээр байгуулагдсан хуулийн этгээд байна. Дампуурлын тухай хуулийн хүрээнд, дампуурлын хэрэг үүсгэх үед дампуурлын хэрэг гүйцэтгэгч (破産管財人), дампуурлын хэрэг дуусах үед дампуурагч этгээд (破産者) байна.

Шууд залгамжлалаар хэргийг түр түдгэлзүүлсэн тохиолдолд, эсрэг тал эсхүл эрх залгамжлан авагчийн эрх залгамжлах хүсэлт (受継申立), эсхүл шүүхийн хэргийг үргэлжлүүлэх захирамж (続行命令)-аар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулдаг.

Эрх залгамжлах хүсэлт (受継申立)-ийг гаргасан тохиолдолд, шүүхийн зүгээс эсрэг талын зохигчид энэ тухай мэдэгдэнэ (ИПХ 127). Мөн шүүхийн зүгээс хүсэлтийг үндэслэлтэй эсэх (эрх залгамжлах этгээд мөн эсэх)-ийг өөрийн эрх хэмжээгээр шалгаж үндэслэлгүй тохиолдолд хүсэлтийг хэрэгсэхгүй болгоно (ИПХ 128.1). Шүүхийн шийдвэр гарсны дараа,

[8] 高橋宏志『重点講義民事訴訟法（上）』456 頁（有斐閣　第 2 版補訂版　2013 年）。

[9] 同上。

дээд шатны шүүхэд бус тухайн шийдвэрийг гаргасан шүүхэд эрх залгамжлах хүсэлтийг гаргаж тухайн шүүх хүсэлтийн үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэнэ (ИПХ 128.2).

Үүнээс гадна, эрх залгамжлах хүсэлтийг гаргах ёстой этгээд нь эрх залгамжлах хүсэлтийг гаргаагүй тохиолдолд, шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг үргэлжлүүлэх захирамж（続行命令）-ийг гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах боломжтой (ИПХ 129).

Гэхдээ зохигч нас барсан хэдий ч, зохигчийн нэрийн өмнөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөөлөн явуулах эрх бүхий төлөөлөгч（訴訟代理人）байх тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх шаардлагагүй[10].

Хуулийн этгээд нэгдэн нийлснээс бусад хэлбэрээр татан буугдаж буй тохиолдолд, татан буугдах үйл явцын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үргэлжлэх боловч нэгэнт татан буугдсан тохиолдолд хэргийг дуусгавар болгоно[11].

Түүнчлэн, шууд залгамжлалын бүхий л тохиолдлуудад хэргийг түдгэлзүүлнэ гэсэн үг биш бөгөөд зарим тохиолдлуудад хэргийг дуусгавар болгодог (訴訟の終了). Тухайлбал, зохигч нас барсан тохиолдолд зохигчийн амины эрх өвлөгдөхгүй тул хэргийг дуусгавар болгодог бөгөөд Япон Улсын тогтсон шүүхийн жишиг үүнийг хүлээн зөвшөөрдөг.

1967 оны Дээд шүүхийн шийдвэрээр “амьжиргааны доод түвшний тэтгэмж авах нэхэмжлэгчийн эрх нь эдийн бус амины эрх байх тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагдахгүйгээр дуусгавар болно” гэж шийдвэрлэсэн (最判昭和 42･5･24 民集 21 巻 5 号 1043 頁). 1976 оны Дээд шүүхийн шийдвэрээр “үрчлэлтийг хүчингүй болгох эрх нь амины эрх тул, нэхэмжлэгч буюу үрчлэгдэгч нас барахтай зэрэгцэн хэрэг дуусгавар болно” гэж шийдвэрлэсэн. Үүнээс үзвэл, гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаан нь амины эрх дээр тулгуурладаг тул, дурдсан шүүхийн жишгүүдэд тулгуурлан хэргийг **түдгэлзүүлэхгүйгээр шууд дуусгавар болгох зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг** (人訴 27.1).

Харин 1970 оны Дээд шүүхийн шийдвэр нь хувь нийлүүлэгчийн компанийг татан буулгахыг шаардах эрх, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр бусд тооцуулах эрх нь хувь нийлүүлэгчийн эдийн засгийн ашиг сонирхлыг ч мөн хамгаалдаг тул, **тухайн эрхүүдийг зөвхөн амины эрх гэж үзэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь залгамжлагдах боломжтой гэж үзсэн** (最判昭和 45･7･15 民集 24 巻 7 号 804 頁).

2. Онцгой залгамжлал（参加承継、引受承継）

Онцгой залгамжлал гэдэг нь нэхэмжлэлийн зүйл гуравдагч этгээдэд шилжсэн тохиолдол бөгөөд үндсэн хоёр төрөлтэй. Эхнийх нь: Оролцооны залгамжлал (参加承継) буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжилж авч буй этгээд нь хүсэлт гаргаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжлан авах тохиолдол (ИПХ 49) бол удаах нь

[10] 伊藤眞『民事訴訟法』262 頁参照（有斐閣　第 6 版　2018 年）。

[11] 伊藤･前掲注（12）261 頁。

Зөвшөөрүүлэх залгамжлал (引受承継) буюу гуравдагч этгээд нэхэмжлэлийн зүйлийг шилжүүлэн авсан тохиолдолд зохигчийн хүсэлтээр гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжлуулах тохиолдол юм (ИПХ 50).

Япон Улсын ИПХ-д зааснаар зохигч нас барсан тохиолдолд хэргийг түдгэлзүүлдэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчийн хүсэлтээр эсхүл шүүх өөрийн эрх хэмжээгээр, эрх залгамжлуулах боломжтой. Гэхдээ бүх төрлийн маргааны шаардлага эрх залгамжлагдана гэсэн үг биш бөгөөд эдийн бус амины эрхийн тухайд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагддаггүй онцлогтой.

4. БНСУ

БНСУ-ын ИХШХШтХ нь эх газрын эрх зүйн системд суурилдаг ба 1910 онд Япон Улс нь БНСУ-ыг эзлэн авснаар Япон Улсын Засгийн газрын тогтоолын дагуу тус улсын хууль тогтоомж БНСУ-д үйлчилж, дэлхийн хоёр дугаар дайн дуустал хэрэгжсэн байна.

Түүхээс үзвэл, Япон Улсын ИХШХШтХ нь 1877 онд батлагдсан ХБНГУ-ын ИХШХШтХ-ийг хэсэгчлэн загварчилсан. Европын иргэний эрх зүйн тогтолцоонд суурилсан Япон Улсын ИХШХШтХ-ийг солонгос хэл рүү орчуулж, 1960 онд БНСУ-ын ИХШХШтХ шинэ хууль батлагдтал Япон Улсын ИХШХШтХ хэрэгжиж эхэлсэн. Иймээс БНСУ-ын ИХШХтХ-ийн зохицуулалт нь Япон Улсын ИХШХтХ-ийн зохицуулалттай нэлээдгүй төстэй байдаг.

ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ТАСАЛДАХ

233 дугаар зүйл (Хэргийн оролцогч нас барсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нас барсны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түүний хууль ёсоор өв залгамжлагч, эсвэл эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих үүрэгтэй бусад этгээд хариуцна.

(2) Өв залгамжлагч нь бүхий л үйл ажиллагааг шилжүүлэн авахаас татгалзах боломжтой байхад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцуулж болохгүй.

234 дүгээр зүйл (Хуулийн этгээдийг нэгтгэсний улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хуулийн этгээд нэгдсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэгдэх замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд, эсхүл нэгдэн нийлсний дараа үлдсэн хуулийн этгээд хариуцна.

235 дугаар зүйл (Хариуцагч эрх зүйн чадамжгүй болсон эсвэл, хууль ёсны төлөөлөгчгүй болсны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд шүүхэд нэхэмжлэл гаргах чадваргүй болсон, эсвэл хууль ёсны төлөөлөгч нь нас барсан, төлөөлөх бүрэн эрхээ алдсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхэд нэхэмжлэл гаргах чадвараа сэргээсэн тал, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч болсон этгээд хариуцна.

236 дугаар зүйл (Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг дуусгавар болсны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)

(1) Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг дуусгавар болсны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинэ итгэмжлэгдсэн төлөөлөгч хариуцна.

237 дугаар зүйл (Өмгөөлөгчийн өмгөөлөх эрх цуцлагдсаны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэх)

(1) Өөрийн нэрийн өмнөөс болон бусдын нэрийн өмнөөс тодорхой мэргэшлийн дагуу өмгөөлөхөөр шүүхэд оролцогч болсон этгээд өмгөөлөх эрх нь цуцлагдсан эсвэл нас барсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ижил мэргэжилтэй хүнд хариуцуулна.

(2) 53 дугаар зүйлд заасны дагуу талуудын томилсон этгээд ур чадвараа алдсан буюу нас барсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талуудын дахин томилсон этгээд, эсвэл шинээр томилогдсон этгээд хариуцна.

239 дүгээр зүйл (Оролцогч тал дампуурсны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)

(1) Хуулийн этгээдийг дампуурсан гэж үзвэл дампуурсанд тооцох шийдвэр гарах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд Өр төлбөрийг нөхөн сэргээх, дампуурлын тухай хуульд заасны дагуу дампуурлын ажиллагаа дуусгавар болсон буюу дампуурсанд тооцогдсон бол төр дампуурсан хуулийн этгээдийн бүхий л үйл ажиллагааг шилжүүлэн авч үргэлжлүүлнэ.

240 дүгээр зүйл (Дампуурлын үйл ажиллагаа дуусгавар болсонтой холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)

(1) Өр төлбөрийг нөхөн сэргээх, дампуурлын тухай хуульд заасны дагуу дампуурах үндэслэлтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсний дараа дампуурлын ажиллагаа дуусгавар болох хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд дампуурсанд тооцогдсон хуулийн этгээдийн бүхий л үйл ажиллагааг шилжүүлж авсан этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

241 дүгээр зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах (эрх залгамжилж авах) хүсэлт гаргах эрх)

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах (эрх залгамжилж авах) хүсэлтийг гаргаж болно.

242 дугаар зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах (эрх залгамжилж авах) тухай хүсэлт гаргах)

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах (эрх залгамжилж авах) хүсэлт гарвал шүүх энэ тухай нөгөө талд мэдэгдэнэ.

243 дугаар зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах (эрх залгамжилж авах) тухай хүсэлтийг шийдвэрлэх)

(1) Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах (эрх залгамжилж авах) авах хүсэлтийг албан ёсоор шалгаж, үндэслэлгүй гэж үзвэл шийдвэр гаргахаас татгалзана.

(2) Шүүхийн шийдвэр гарсны дараа тасалдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайд тухайн шийдвэр гаргасан шүүх шийдвэр гаргана.

244 дүгээр зүйл (Шүүхийн эрх хэмжээгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх)

(1) Хэрэв талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхийг даалгасан захирамж гаргаж болно.

245 дугаар зүйл (Шүүх үүргээ гүйцэтгэж чадаагүйн улмаас тасалдах)

(1) Байгалийн гамшиг болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шүүх үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд уг нөхцөл байдал дуусах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тасалдана.

246 дугаар зүйл (Оролцогч талын онцгой нөхцөл байдлын улмаас хэргийг тасалдах)

(1) Талууд тодорхойгүй хугацаагаар давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй бол шүүхийн тогтоолоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тасалдуулах шийдвэр гаргаж болно.

(2) Шүүх (1)-д заасан шийдвэрийг хүчингүй болгож болно.

247 дугаар зүйл (Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн, тасалдсаны үр дүн)

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тасалдсан шүүхийн шийдвэрийг мэдэгдэнэ.

(2) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, тасалдуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг зогсоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь шилжүүлж авах тухай мэдэгдсэн, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахин эхэлсэн үеэс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шинээр эхэлнэ.

БНСУ-ын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх залгамжлах нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор "хэргийг түдгэлзүүлэх", эсхүл "тасалдах арга" хэмжээг шүүхээс авдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа <u>тасалдсан</u> бол шүүгч өөрийн эрх хэмжээгээр хариуцагч этгээдийг тогтоодог. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг тасалдсан болон түдгэлзсэн бол хариуцагчийг шинээр томилсон үеэс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шинээр эхэлдэг.

5. БНХАУ

Хэргийг хянан хэлэлцэх явцад хэргийн оролцогч (нэхэмжлэгч, хариуцагч) хувь хүн нас барсан тохиолдолд түүний эрх залгамжлагч нас барсан этгээдийн шүүх хуралдаанд оролцох эрхийг өвлөн нэхэмжлэгч, хариуцагчаар хэрэгт оролцож шүүхийн процессыг үргэлжлүүлэх боломжтой.[12] Эрх залгамжилж буй этгээдийн сонголтоос хамаарч шүүх хуралдааны эрх залгамжлал үүсэхгүй байх боломжтой.[13]

Эрх залгамжлагч нь өв залгамжлалаас татгалзах эрхтэй бөгөөд энэ үед өвлүүлэгчийн бусад этгээдийн өмнө хүлээх үүргийг хариуцах шаардлагагүй юм. Энэ тохиолдолд өвлүүлэгч нь хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчийн алинаар оролцож байснаас үл хамааран эрх залгамжилж буй этгээдэд шүүх хуралдаанд эрх залгамжлахаас татгалзах сонголт нь байдаг. Нөгөө талаас хэрэв эрх залгамжлагч өвийг хүлээж авахаас татгалзаагүй бол өвлүүлэгч этгээд шүүх хуралдаанд хариуцагчаар оролцож үүрэг, хариуцлага хүлээж байсан тохиолдолд өвлөгч нь түүний иргэний процесс дахь байр суурийг заавал орлох ёстой. Харин өвлүүлэгч нь нэхэмжлэгч байсан тохиолдолд өвлөгчид шүүх хуралдаанд эрх залгамжлах эсэхээ сонгох эрх нь чөлөөтэй хэвээр байна.

БНХАУ-ын ИПХ-ийн 150 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэргийн оролцогч нас барсан үеэс түүний өв залгамжлагч шүүх хуралдаанд эрх залгамжлах эсэхээ илэрхийлэх хүртэл хугацаанд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх шаардлагатай. Хуулийн этгээд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах нь үүнтэй төстэй бөгөөд бас тодорхой ялгаатайгаар явагддаг.

Ерөнхийдөө иргэний процессын явцад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаа хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан тохиолдолд зарчмын хувьд түүний эд хөрөнгийн эрх, үүргийг хүлээн авч буй өөр хуулийн этгээд байгууллага татан буугдсан хуулийн этгээдийн иргэний процессын эрхийг мөн залгамжлан авч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ. Жишээлбэл: хуулийн этгээд хуваагдсан эсхүл нэгдсэн тохиолдолд тухайн нэг буюу хоёр шинэ хуулийн этгээд нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан буугдсан хуулийн этгээдийн эрхийг залгамжлан авч үргэлжлүүлнэ. Хэрэв хэргийн оролцогч хуулийн этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад эрх зүйн чадвар дуусгавар болсон бол тус хуулийн этгээдийг удирддаг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч эсхүл гүйцэтгэх удирдлага нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан оролцоно.

БНХАУ-ын ИПХ-ийн 150 дугаар зүйлд[14] зааснаар дараах нөхцөл байдал үүсвэл хэргийг түдгэлзүүлнэ:

1. *Хэргийн оролцогчдын аль нэг нь нас барсан ба эрх залгамжлах этгээдийг хэрэгт оролцох эсэхээ илэрхийлэхийг хүлээх шаардлагатай;*
2. *Хэргийн оролцогчдын аль нэг нь эрх зүйн чадваргүй болсон бөгөөд хууль ёсны төлөөлөгч тодорхой болоогүй байгаа;*
3. *Хэргийн оролцогч хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан бөгөөд эрх, үүргийг нь хүлээн авах этгээд тодорхойгүй байгаа;*
4. *Хэргийн оролцогчдын аль нэг нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас оролцох боломжгүй болсон;*
5. *Тухайн хэргийг шийдвэрлэхээс өмнө өөр хэргийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай;*
6. *Бусад хэргийг түдгэлзүүлэх шаардлагатай нөхцөл байдал үүссэн.*

[12] 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）第 298 页

[13] 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）第 299 页

[14] 中华人民共和国民事诉讼法第一百五十条 http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm Сүүлд үзсэн: 2022.11.09

Иргэний хэрэг хянан шүүхэд хянан шийдвэрлэх явцад ямар нэгэн шалтгаан эсхүл нөхцөл байдлаас болж түр хугацаагаар зогсож байгааг хэрэг түдгэлзэх гэж нэрлэдэг. Түдгэлзүүлсэн хугацаанд тухайн түдгэлзүүлсэн шалтгаан, нөхцөл байдал арилах хүртэл шүүхээс ямар нэгэн ажиллагаа хийгдэхгүй. Дээр дурдсан хэргийг түдгэлзүүлэх шалтгаан арилбал хэргийг үргэлжлүүлнэ.

ИПХ-ийн 150 дугаар зүйлд хэргийг түдгэлзүүлэх 6 үндэслэлийг зааж өгснийг 3 төрөлд хуваан авч үзэж болно.

1. Нэхэмжлэлийн гол зүйл хүлээгдэж байгаа: маргааны аль нэг тал болох иргэн нас барсан бөгөөд эрх залгамжлах этгээд шүүх хуралдаанд оролцох эсэхээ илэрхийлэхийг хүлээх шаардлагатай; маргааны аль нэг тал болох хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан ба түүний эрх, үүргийг залгамжлах этгээд тодорхойгүй байгаа; маргааны аль нэг тал иргэний процессын эрхээ алдсан ба хууль ёсны төлөөлөгч тодорхойгүй байгаа гэх мэт.
2. Форс Мажор: маргааны аль нэг тал давагдашгүй хүчин зүйлийн улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон нөхцөл.
3. Бусад хэргийн оролцоо: Хэргийг шийдвэрлэхэд өөр хэргийг шийдвэрлэсэн шийдвэр ач холбогдолтой бөгөөд хараахан эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа тохиолдол.

Хуулийн этгээдийн эрх залгамжлах этгээдийг тодорхойлоход ихээхэн хугацаа зарцуулдаг тул ИПХ-ийн 150 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хэргийг түдгэлзүүлдэг байна.[15] Шүүх хэргийн оролцогчдын хүсэлтийг үндэслэн эсхүл өөрийн санаачилгаар дээрх нөхцөл байдлууд үүссэн бол хэргийг түдгэлзүүлэх захирамж гаргадаг.[16]

БНХАУ-ын ИПХ-ийн тайлбарын 55 дугаар зүйлд зааснаар хэргийн оролцогчдын аль нэг нь нас барсан эрх залгамжлах этгээдийг иргэний хэрэгт оролцох эсэхээ илэрхийлэх шаардлагатай үед шүүхээс хэргийг түдгэлзүүлэх захирамж гарна. Ардын шүүх цаг алдалгүй өвлөгч этгээдэд иргэний хэрэгт тал болон оролцох болон өвлүүлэгчийн эхлүүлсэн иргэний хэрэг нь өвлөгчид хүчинтэй болохыг мэдэгдэнэ.[17]

Хэргийг түдгэлзүүлсний дараа процессыг үргэлжлүүлэх шаардлагагүй бол хэргийг дуусгавар болгоно. ИПХ-ийн 151 дүгээр зүйлд зааснаар дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно:

1. Нэхэмжлэгч нас барсан бөгөөд эрх залгамжлах этгээд байхгүй эсхүл эрх залгамжлах этгээд нэхэмжлэлийн эрхээс татгалзсан;
2. Хариуцагч нас барсан бөгөөд өв залгамжлагч байхгүй, үүргийг нь хариуцах хүн байхгүй;
3. Гэрлэлт цуцлуулах хэрэгт хэргийн оролцогч нас барсан;
4. Хүүхэд эсхүл эцэг эхээ тэжээн тэтгүүлэх, үрчлэлт цуцлах зэрэг хэргүүдэд хэргийн оролцогч нас барсан.[18]

ИПХ-ийн 151 дүгээр зүйлд зааснаар хэргийн оролцогчдын аль нэг нь нас барсан эрх залгамжлагч байхгүй бол эсхүл гэрлэлт цуцлах, үрчлэлтийг хүчингүй болгуулах, хүүхдийн тэтгэмж гаргуулах зэрэг нэхэмжлэлд аль нэг тал нас барсан бол шүүх иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргана.

---

[15] 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）第 299 页

[16]王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）第 300 页

[17] 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释第五十五条 https://www.spp.gov.cn/spp/flfg/sfjs/201502/t20150205_90222.shtml (Сүүлд үзсэн: 2022.11.09).

[18] 中华人民共和国民事诉讼法第一百五十一条 http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm (Сүүлд үзсэн: 2022.11.09).

БНХАУ-ын ИПХ-ийн тайлбарын 322 дугаар зүйлд зааснаар *давж заалдсан* хэргийн үед хэргийн оролцогчид нас барсан эсхүл татан буугдсан бол ардын шүүх хуулийн дагуу түүний эрх, үүргийг өвлөж буй этгээдэд иргэний хэрэгт оролцохыг мэдэгдэнэ. Давж заалдах шатанд уг үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох шаардлагатай бол ИПХ-ийн 151 дүгээр зүйлд заасныг баримтлан хэрэгсэхгүй болгоно.[19]

ИПХ-ийн 232 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэх этгээд буюу иргэн нас барсан бол түүний хөрөнгөнөөс өрийг барагдуулна. Шийдвэр гүйцэтгэх этгээд буюу хуулийн этгээд татан буугдсан бол түүний эрх үүргийг хүлээн авч буй этгээд үүргийг биелүүлнэ.

ИПХ-ийн 22 дугаар бүлэгт шийдвэр гүйцэтгэлийг түдгэлзүүлэх болон дуусгах талаар дараах байдлаар зохицуулсан.

ИПХ-ийн 256 дугаар зүйл. Дараах нөхцөл байдалд Ардын шүүх захирамж гаргаж шийдвэр гүйцэтгэлийг түдгэлзүүлнэ:

1. *Шийдвэрийн гүйцэтгэлийг сунгуулахаар хүсэлт гаргасан;*
2. *Хэрэгт хамааралгүй этгээд шийдвэр гүйцэтгэлд үндэслэл бүхий татгалзал гаргасан;*
3. *Хэргийн оролцогчдын аль нэг иргэн нас барсан ба эрх залгамжлах эсхүл үүрэг хариуцах этгээдийг гарч ирэхийг хүлээх шаардлагатай;*
4. *Хэргийн оролцогчдын аль нэг болох хуулийн этгээд бусад байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон, эрх үүрэг хүлээн авч буй этгээд тодорхойгүй.[20]*

ИПХ-ийн 257 дугаар зүйл. Дараах тохиолдолд Ардын шүүх шийдвэр гүйцэтгэлийг дуусгавар болгохоор захирамж гаргана:

1. *Хүсэлт гаргасан этгээд хүсэлтээсээ татгалзсан;*
2. *Шийдвэр гүйцэтгэл явуулах үндэслэл болсон баримт бичгийг хүчингүй болгосон;*
3. *Шийдвэр гүйцэтгэх этгээд болон иргэн нас барсан, гүйцэтгэл явуулах өв залгамжлал байхгүй, үүрэг хариуцах этгээд байхгүй;*
4. *Үр хүүхэд, эцэг эхээ тэжээн тэтгэх, хүүхэд асрахтай холбоотой зардал гаргуулах эрх бүхий этгээд нас барсан;*
5. *Шийдвэр гүйцэтгэх этгээд буюу иргэн амьдралын хүнд бэрхшээлээс шалтгаалан өрийг төлөх боломжгүй, орлогын эх үүсвэргүй, хөдөлмөрийн чадвараа алдсан;*
6. *Ардын шүүх бусад нөхцөл байдлын улмаас шийдвэр гүйцэтгэлийг дуусгавар болгох шаардлагатай гэж үзсэн.[21]*

ИПХ-ийн 258 дугаар зүйл. Түдгэлзүүлсэн болон дуусгавар болгосон захирамжийг хэргийн оролцогчид хүргүүлмэгц хүчин төгөлдөр болно.[22]

ИПХ-ийн тайлбарын 475 дугаар зүйлд зааснаар хэрэв шийдвэр гүйцэтгэх иргэн нас барсан бөгөөд түүний өв залгамжлагч өвийг хүлээж авахаас татгалзаагүй бол Ардын шүүх захирамж гаргаж шийдвэр гүйцэтгэх этгээдийг солих бөгөөд өв залгамжлагч этгээд өвлүүлэгчийн эд хөрөнгийн хэмжээгээр өрийг хариуцна. Хэрэв өвлөгч өвөөс татгалзсан бол Ардын шүүх нас барсан этгээдийн хөрөнгөөс шууд өрийг барагдуулна.[23]

БНХАУ-ын ИПХ болон ИПХ-ийн тайлбарт зохицуулснаас үзэхэд зохигчид нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд БНХАУ-ын ИПХ-ийн 150 дугаар зүйлд зааснаар тухайн хэргийг түдгэлзүүлдэг байна. Иймхүү түдгэлзүүлэх хугацаанд шүүхээс нас барсан

[19] 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释第三百二十二条 https://www.spp.gov.cn/spp/flfg/sfjs/201502/t20150205_90222.shtml (Сүүлд үзсэн: 2022.11.09).

[20] 中华人民共和国民事诉讼法第二百五十六条 http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm (Сүүлд үзсэн: 2022.11.09).

[21] 中华人民共和国民事诉讼法第二百五十七条 http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm (Сүүлд үзсэн: 2022.11.09).

[22] 中华人民共和国民事诉讼法第二百五十八条 http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm (Сүүлд үзсэн: 2022.11.09).

[23] 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释第四百七十五条 https://www.spp.gov.cn/spp/flfg/sfjs/201502/t20150205_90222.shtml (Сүүлд үзсэн: 2022.11.09).

этгээдийн өвлөгчид хандан тухайн хэрэгт эрх залгамжлан оролцох эсэхийг тодруулдаг. Хэрэв нэхэмжлэгч нас барсан бол түүний өв залгамжлагч тухайн хэрэгт эрх залгамжлан оролцох эсэх нь өөрийнх нь сонголтын асуудал байдаг бөгөөд хэрэв шүүхэд оролцох эрхээсээ татгалзсан тохиолдолд хэргийг ИПХ-ийн 151 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болгоно.

Харин хариуцагч нас барсан тохиолдолд өв залгамжлагч өвийг хүлээн авсан эсэхээс хамааран сонгох эрх нь хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл нас барсан хариуцагчийн өвлөгч өвийг хүлээж аваагүй бол түүнд эрх залгамжлахаасаа татгалзах эрх нь хадгалагдах ба хариуцагчийн өвлөгч өвийг хүлээж авсан бол заавал шүүх хуралдаанд нас барсан хариуцагчийн оронд хариуцагчаар оролцож хэргийг үргэлжлүүлэх бөгөөд энэ тохиолдолд шүүхээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан тохиолдолд түүний эд хөрөнгийн эрх үүргийг шилжүүлэн авсан этгээд эрх залгамжлагчаар хэрэгт оролцдог. Давж заалдах болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд мөн адил журам үйлчилдэг байна. Шийдвэр гүйцэтгэлийн үед хариуцагч нас барсан ба өвлөгч өвийг хүлээн аваагүй бол шууд нас барсан хариуцагчийн хөрөнгөөс өрийг барагдуулдаг.

6. ОХУ[24]

ОХУ-ын ИХШХШтХ-ийн *44 дүгээр зүйлд* [25] “*Правопреемство*” буюу “*эрх залгамжлал*”-ийн талаар зохицуулсан.

ОХУ-ын ИХШХШтХ-д зааснаар:

Эрх зүйн харилцаанд оролцогч талуудын хооронд маргаан үүссэн эсхүл шүүхийн шийдвэрээр маргаантай болох нь тогтоогдсон талуудын аль нэг нь үүргээсээ татгалзсан тохиолдолд (иргэн нас барах, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, өрийг шилжүүлэх, аль нэг талын үүрэг, хариуцлага нь өөрчлөгдсөн бусад тохиолдолд) шүүх талуудыг орлох эрх бүхий этгээд буюу эрх залгамжлах эрхтэй этгээдээр орлуулахыг хүлээн зөвшөөрнө. Эрх залгамжлал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд боломжтой (44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт).

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орохоос өмнөх эрх залгамжлагчийн үйлдлүүд нь эрх залгамжлагчийг орлож буй этгээдэд чухал байгаагийн адилаар эрх залгамжлагчид өөрт нь мөн адил чухал (44 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт).

Хууль ёсны эрх залгамжлагчийг солих, солихоос татгалзах тухай шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхтэй байна (44 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт).

Улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг түдгэлзүүлэхтэй холбоотойгоор, ОХУ-ын *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 110 дугаар зүйлийн 1-т* заасны дагуу “*Хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхтэй зэрэгцэн дуусгавар болоогүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг түдгэлзүүлнэ.”*

“*Хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээсэн өдрөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны явц үргэлжилнэ*” хэмээн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг түдгэлзүүлэх заалтыг хуульчилсан (*110 дугаар зүйлийн 2-т*).

Харин хуулийн *17 дугаар бүлэгт*[26] “*Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх*” талаар зохицуулсан ба “*Шүүх маргаан бүхий эрх зүйн харилцаанд эрх залгамжлалыг зөвшөөрсөн тохиолдолд хэргийн оролцогч буюу бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нас*

[24] http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/ (Сүүлд үзсэн: 2022.11.10).

[25] http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/d6518eb21a0f384d693f49a935f07e369880949c/ (Сүүлд үзсэн: 2022.11.10).

[26] http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/084934e66a31b8e207f4c2e53cae48e039fe7922/ (Сүүлд үзсэн: 2022.11.10).

барсан бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үүрэгтэй" байна (*215 дугаар зүйл*).

Шүүх хэргийн оролцогчдын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэргийн оролцогч буюу бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд болох хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах тохиолдолд түдгэлзүүлэх эрхтэй байна (*216 дугаар зүйл*).

Энэ хуулийн 215 дугаар зүйлийн 2 болон 3 дах хэсэгт зааснаар хэргийн оролцогчийн хууль ёсны залгамжлагчийг тогтоох эсхүл эрх зүйн чадамжгүй этгээдэд хууль ёсны төлөөлөгч томилох хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж эцсийн хугацааг тогтоож өгнө (*217 дугаар зүйл*).

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай шүүхийн шийдвэрийн эсрэг гомдол гаргаж болно (*218 дугаар зүйл*).

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхэд хүргэсэн нөхцөл байдлыг арилгасны дараа тухайн хэргийн оролцогчдын өргөдөл болон шүүхийн санаачилгаар сэргээнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээхэд шүүх энэ талаар хэргийн оролцогчдод мэдэгдэнэ хэмээн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин нээх тухай зохицуулсан байна (*219 дугаар зүйл).

Мөн түүнчлэн ОХУ-д бие даасан Арбитрын шүүх байдаг бөгөөд шүүхийн хүрээнд шийдвэрлэх хэрэг маргаантай холбогдох үйл ажиллагааг зохицуулахаар 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан "Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"-ийг даган мөрдөж эхэлсэн. Иймд ОХУ-ын Үндсэн хууль болон Холбооны Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдсан ОХУ-ын арбитрын шүүх нь аж ахуй эрхлэх болон эдийн засгийн бусад үйл ажиллагааны хүрээнд холбогдох маргааныг шийдвэрлэх, тэдгээрийн бүрэн эрхэд хамаарах бусад хэргийг хянан шийдвэрлэх замаар чиг үүргээ хэрэгжүүлдэг байна[27].

Ийнхүү арбитрын шүүхээр шийдвэрлэгдэх хэрэг маргааны хүрээнд "эрх залгамжлал"-тай холбогдох зүйл, заалтыг "Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд (цаашид АХХШтХ гэх) зохицуулж өгсөн[28] бөгөөд тус хуульд зааснаар:

"*Маргаан бүхий эрх зүйн харилцаанд эрх залгамжлалыг зөвшөөрсөн бол тухайн хэргийн оролцогч эсхүл маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нас барсан тохиолдолд арбитрын шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ*" (*143 дугаар зүйлийн 1-ийн 3 дэх хэсэгт*).

Тус хуулийн 150 дугаар зүйлийн 1-ийн 6 дах хэсэгт заасны дагуу "*хэргийн оролцогч болох иргэн нас барсан тохиолдолд маргаантай эрх зүйн харилцаанд эрх залгамжлалыг хүлээн зөвшөөрөөгүй бол арбитрын шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоон, эрх зүйн харилцааг дуусгавар болгодог*" хэмээн тус тус зохицуулжээ.

ОХУ-ын Иргэний хэргийн шүүх нь эрх залгамжлалыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ тухай ИХШХШтХ-даа зохицуулсан.

"Зохигчдыг солих" буюу маргааны талуудын аль нэг нь үүргийн гүйцэтгэлийг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд эрх залгамжлах өөр этгээдийг орлуулж, эрх залгамжлах ажиллагааг явуулдаг. Иймхүү эрх залгамжлах үндэслэл нь маргааны талуудын аль нэг нь нас барах, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, өр шилжүүлэх, аль нэг талын үүрэг, хариуцлага өөрчлөгдсөн, мөн талууд үүргээсээ татгалзсан тохиолдол болно.

[27] https://vip.1jur.ru/?utm_source=arbitr-praktika.ru&utm_medium=refer&utm_campaign=refer_arbitr-praktika.ru_content_link_native_middle&utm_term=2482&utm_content=art#/document/99/901821334/ZA00M462LP/ (Сүүлд үзсэн: 2022.11.10).

[28] https://vip.1jur.ru/?utm_source=arbitr-praktika.ru&utm_medium=refer&utm_campaign=refer_arbitr-praktika.ru_content_link_native_middle&utm_term=2482&utm_content=art#/document/99/901821334/ZA00M462LP/ (Сүүлд үзсэн: 2022.11.10).

Тус тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг орлон гүйцэтгэх этгээдэд эрх залгамжлуулахын тулд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг. Уг хуулийн зохицуулалт нь чухал ач холбогдолтой хэдий ч нэхэмжлэгч болон хариуцагчийн талаас, мөн тэдгээрийг орлох этгээдийн талаас ямар эрх, үүргийг хэрэгжүүлэх, эрх залгамжлан авах этгээдэд тавигдах эрх зүйн шаардлага болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хугацааны талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа нь дутагдалтай байна гэж үзлээ. Энэ талаараа ОХУ-ын эрх зүйн зохицуулалт манай улсын ИХШХШтХ-ийн зохицуулалттай төстэй байна.

Мөн зохигчдын эрх, үүргийг эрх залгамжлан авах этгээдийг солихын тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлснээр дээр дурдсан нөхцөл байдлууд арилсны дараа хэргийн оролцогчдын өргөдөл болон шүүхийн санаачилгаар хэргийг дахин нээж, сэргээн явуулдаг. Энэ талаар зохицуулалт ИХШХШтХ-д болон АХШХШтХ-ийн зохицуулалтад тусгагджээ. Үүнд, “хэрэв маргаантай эрх зүйн харилцаанд эрх залгамжлалыг өөр этгээдэд шилжүүлэх, ийнхүү тухайн этгээд үүргийн гүйцэтгэлийг орлон гүйцэтгэхийг зөвшөөрөөгүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүр мөсөн зогсоох” хэмээн эрх зүйн үр дагаврын талаар дурдсан онцлог бүхий зохицуулалтыг тусгасан.

ХОЁР. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан судалгааны үндсэн дээр дараах дүгнэлтийг боловсруулаа:

1. Зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсантай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлагдах явдлыг улс орнууд ойлголтын хувьд өөр хоорондоо ялгаатай нэр томьёогоор дотоодын хууль тогтоомждоо зохицуулсан байх боловч хэргийг дуусгавар болгохтой холбоотойгоор үр ашиггүй зардал бий болохоос сэргийлэх, маргааныг эцэслэн шийдвэрлэх, иргэний эрх зүйн субъектийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүднээс аль болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болголгүйгээр цаашид үргэлжлүүлэх (эрх залгамжлуулах) нийтлэг үзэл санааг баримталсан байна.

   Тодруулбал, АНУ нь “нийтлэг эрх зүйн систем” (common law)-ийг буюу шүүхийн жишгийн эрх зүйг баримталдаг улс хэдий ч АНУ-ын бүх муж улсад нэгэн адил үйлчлэх Холбооны хуулиар дамжуулан “зохигч нас барсан тохиолдолд” тухайн зохигчийг эрх залгамжлагчаар солих боломж болон арга замыг хуульчилсан, ИПХ-ийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эрх залгамжлагчаар зохих этгээдийг томилох (талуудын зүгээс хүсэлт гаргах, зарим муж улсад хүсэлт гаргаагүй бол шүүхээс “зохистой арга хэмжээг авах” буюу эрх залгамжлагчийг өөрийн эрх хэмжээний хүрээнд томилох агуулга бүхий заалт тусгасан) талаар дэлгэрэнгүй хуульчилж өгчээ.

   Түүнчлэн, эх газрын эрх зүйн системд харьяалагдах улсууд ч нэгэн адил ИПХ-даа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх зохицуулалтуудыг тусгаж өгсөн байна. Эрх залгамжлал тогтоох нөхцөл байдал үүссэн (зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан)-тэй холбоотойгоор судалгааны хүрээнд хамруулсан улсууд зарчмын хувьд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх” үр дагаврыг хуульчилсан байна. Тухайлбал, АНУ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч солих (эрх залгамжлах) хүсэлт гарах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг (Холбооны Иргэний процессын хууль 25.a.1). БНХАУ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлах хүсэлт гарах хүртэл хэргийг түдгэлзүүлэх шаардлагатай байдаг (ИПХ 150.1). ОХУ мөн манай улстай адилаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үр дагаврыг хуульчилсан (ИХШХШтХ 215). БНСУ-д ч нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг (ИХШХШтХ 233). Харин Япон Улсад зохигч нас барсантай холбоотойгоор шүүхээс хэргийг түдгэлзүүлдэг хэдий ч (ИПХ 124.1.1) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөөлөх эрх бүхий этгээд байгаа тохиолдолд хэргийг түдгэлзүүлэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд явуулдаг онцлогтой байна.

2. Гэсэн хэдий ч хуулийн этгээд татан буугдах ойлголт, төрөл болон ажиллагаа нь улс орон болгоны хувьд харилцан адилгүй байдаг тул түүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үзүүлэх нөлөөний талаар төсөөтэй талыг олж харахад хүндрэлтэй байна. Гэхдээ, Япон Улс, БНСУ болон БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтаас ажиглагдсан нийтлэг тал нь “хуулийн этгээд өөр хуулийн этгээдтэй нэгдэн нийлсэн тохиолдолд шинээр байгуулагдсан хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлан авдаг” явдал юм.

Зарим улсын онцлогоос дурдвал: Япон Улсад хуулийн этгээд татан буугдах ажиллагааны хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үргэлжилдэг хэдий ч нэгэнт татан буугдсан бол хэргийг дуусгавар болгодог. Түүнчлэн, БНХАУ-д хуулийн этгээд татан буугдсан бөгөөд түүний эрх, үүргийг хүлээн авах этгээд тодорхойгүй тохиолдолд, шүүхээс хэргийг түдгэлзүүлдгээс гадна онцлог анхаарал татахуйц нь хуулийн этгээд татан буугдсан хэдий ч хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч зэрэг удирдах этгээдүүд эрх залгамжлах боломжтой талаар холбогдох эх сурвалжид дурдсан явдал юм.

3. Дээрх байдлаар хэргийг түдгэлзүүлсний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагддаг нийтлэг тал улс орнуудад ажиглагдах боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах, хэргийг сэргээн явуулах тодорхой ажиллагаа болон журмууд харилцан адилгүй байна.

   Зохих этгээдийн хүсэлтийг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагдах нь ерөнхий зарчим хэдий ч зарим улс орнууд зохих этгээд хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх, эрх залгамжлуулах боломжийг хуульчилж өгсөн байдаг.

   Тухайлбал, ИБУИНХУ-д нэхэмжлэгчийн нэрийн өмнөөс хэргийг хүлээн авах этгээд хүсэлт гаргаагүй тохиолдолд, шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг үргэлжлүүлэх эсхүл зохих этгээдийг томилох боломжтой (ИПХ 19.8.1). Япон Улсад зохих этгээдүүд эрх залгамжлах хүсэлтийг гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх захирамжийг гаргах боломжтой (ИПХ 129). БНСУ-д ч мөн адил шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх захирамжийг гаргадаг (ИХШХШтХ 244). ОХУ-д манай улсын эрх зүйн зохицуулалттай төстэй байдлаар “хэргийг түдгэлзүүлсэн шалтгаан арилмагц зохигчдын хүсэлт эсхүл шүүхийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх” боломжийг хуульчилсан байна (ИХШХШтХ 219).

   Харин АНУ-ын Холбооны ИПХ-ийн хүрээнд зохих этгээдүүд тодорхой хугацааны дотор хүсэлт гаргаагүй тохиолдолд хэргийг дуусгавар болгохоос өөр аргагүй бөгөөд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, сэргээх боломжгүй (25.а.1). Гэхдээ, давж заалдах шатанд зохигч нас барсан тохиолдолд, *шүүх тохиромжтой арга хэмжээг авна* гэж шүүхийн эрх хэмжээг хүлээн зөвшөөрсөн (Давж Заалдах журмын холбооны тухай хууль 43.а.1) төдийгүй АНУ-ын муж улсууд хэргийг үргэлжлүүлэх, сэргээх боломжийг илүү уян хатан байдлаар дотоодын хууль тогтоомждоо зохицуулсан байдаг. БНХАУ-ын хувьд зохих этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлалаас татгалзах эрхтэй (ИПХ 150.1). Энэ хүрээнд нэхэмжлэгчийн эрх, үүргийг залгамжлах ёстой этгээд хүлээн авахаас татгалзвал хэргийг хэрэгсэхгүй болгодог бол хариуцагчийн тухайд зохих этгээд өвийг хүлээн авсан эсэхээс хамаарч хэргийг хүлээн авах ёстой юу үгүй юу гэдэг нь шийдэгддэг. Нэмж дурдахад, АНУ, Япон Улс болон БНСУ-д маргааны нэг тал нас барсантай холбогдуулан нөгөө тал нь эрх залгамжлуулах хүсэлт гаргах боломжтой талаар тодорхой зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг.

4. Мөн, улс орнууд хэргийг түдгэлзүүлэх эсхүл сэргээх хүсэлтийг гаргах хугацааг онцолж үзсэн байгаа боловч яг тодорхой хугацаа зааж өгсөн нь АНУ байна. Тодруулбал, *нас барсан тухай мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дотор зохигчийг солих хүсэлтийг*

гаргаагүй бол, шүүх хэргийг хэрэгсэхгүй болгодог (Холбооны Иргэний Процессын хууль 25.а.1).

Үүнээс гадна, зохигч нас барсан тохиолдолд бүхий л маргааны шаардлагын тухайд хэргийг түдгэлзүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагдана гэсэн үг биш бөгөөд улс орнууд эдийн бус маргааны шаардлагын тухайд хэргийг шууд дуусгавар болгох хандлагатай байна. Тухайлбал, Япон Улсад амины эрхтэй холбоотой шаардлагын тухайд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагддаггүй бөгөөд холбогдох шүүхийн жишиг болон хууль тогтоомж хэргийг дуусгавар болгохоор зохицуулсан байдаг. Үүнтэй адилаар БНХАУ-ын хувьд гэрлэлт цуцлуулах, үр хүүхэд эсхүл эцэг эхээ тэжээн тэтгэх, үрчлэлт цуцлах зэрэг маргааны оролцогч нас барсан тохиолдолд хэргийг түдгэлзүүлэх шаардлагагүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгодог.

Дээрхээс үзвэл, улс орнууд зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчим болон үр дагаврыг (хэргийг түдгэлзүүлэх) төсөөтэй байдлаар тодорхой хуульчилж өгсөн байна гэж дүгнэж болно.

Харин илүү нарийвчилсан түвшинд буюу ямар төрлийн маргааны шаардлагын эрх, үүрэг залгамжлагдах вэ, хэдий хугацааны дотор хүсэлт гаргах вэ, шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх боломжтой юу, давж заалдах шатанд хэргийг хэрхэх вэ зэрэг асуудлуудын тухайд өөр хоорондоо ялгаатай байдлаар гадаадын орны эрх зүйн зохицуулалтад тусгасан байдал ажиглагдлаа. Эдгээр нарийн асуудлуудын хувьд шүүхийн эрх хэмжээг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн гэж үзэх боломжтой байна. Түүнчлэн шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад эрх залгамжлах явдалтай холбоотой нэлээдгүй олон нөхцөл байдлыг харгалзаж үзэх шаардлага тулгардаг тул хэргийг шууд шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдал үүсдэг. Өөрөөр хэлбэл, зохигч нас барсан тохиолдолд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэдий хүртэл үргэлжилсэн байсан бэ, нэхэмжлэгч хариуцагчийн хэн нь нас барсан бэ, ямар төрлийн маргааны шаардлага вэ (маргаан нь амины эрхтэй хамаатай эсэх г.м), эрх залгамжлах этгээд бий юу зэрэг хэд хэдэн нөхцөл байдлыг харгалзаж үзэх шаардлагатай бөгөөд үүнтэй холбоотойгоор хэрэг маргааныг хянан шийдвэрлэх арга зам гадаад улс тус бүрд харилцан адилгүй байна.

ЭХ СУРВАЛЖ

Ном, сурах бичиг:

1. Монгол Улсын Дээд Шүүх, ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР (Мөнхийн үсэг Нэмэлт өөрчлөлттэй 3 дахь хэвлэл 2014)
2. 渡部美由紀他『民事訴訟法』（日本評論社　2016 年）
3. 高橋宏志『重点講義民事訴訟法（上）』（有斐閣　第 2 版補訂版　2013 年）
4. 伊藤眞『民事訴訟法』（有斐閣　第 6 版　2018 年）
5. 王亚新, 陈杭平, 刘君博著“中国民事诉讼法重点讲义”（第二版）

Цахим эх сурвалж:

1. https://jflawfirm.com/what-happens-if-someone-dies-before-settlement-in-a-civil-lawsuit/
2. https://www.thejusticelawyer.com/blog/what-if-the-defendant-dies-in-litigation/
3. https://www.oflaherty-law.com/learn-about-law/is-a-lawsuit-in-illinois-terminated-if-one-of-the-parties-dies
4. https://www.truittlawoffices.com/blog/if-someone-dies-lawsuit-pending/
5. https://www.hughjames.com/blog/what-happens-to-a-claim-when-a-person-dies
6. http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm
7. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/
8. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/d6518eb21a0f384d693f49a935f07e369880949c/